

## Хуурын үлгэрийн аман хүүрнэл

Б.Цэцэнтуяа\*

Өвөр Монголын Их Сургууль,  
Монгол Судлалын Дээд Сургууль

### Хураангуй

Аман зохиол сонгодог бичгийн уран зохиолоос ялгарах нэгэн өвөрмөц арга бол аман хүүрнэлийн загвараар аливаа үлгэр туульсын зүйлийг аялгуутай болон хүүрнэл өгүүлэх маягаар уламжлуулан өвлүүлэх нэгэн хэлбэр болно. Түүний нэг жишээ бол Хуурын үлгэрийн аман хүүрнэлийн загвар юм. Хуурын үлгэрийг хуурч дөрвөн утаст хуур хөгжмийн ая айзамд нийцүүлэн үлгэрийн утга агуулгыг дуулах маягтайгаар хэлдэг нь нэг төрлийн тоглолтын шинж чанартай гэж болно. Орчин үед тус хуурын үлгэрийн уламжлалыг Өвөр Монголын зүүн хэсэгт өргөнөөр уламжлах дэлгэрүүлсэн нь эдүгээ бидний мэддэгээр “Бэнсэн үлгэр” хэмээх нэрийдэлтэй болжээ. Энэхүү нэр нь хуурын үлгэрийн хүүрнэлийн сэдэв, агуулгатай шууд холбогдох тул хуурын үлгэрийн эхэн үеийн хөгжил цэцэглэлтийн үеийг судлахад Хятад үндэстний түүх, төрийн үлгэр, түүхэн туужийн дэвтэр буюу тэдгээрийн монгол орчуулгын дэвтрүүдээр хүүрнэлийн эх загвар болгож байв. Хуурын үлгэр нь хоёр зуу илүү жилийн хөгжлийн түүхэнд хуурын үлгэрийн эх дэвтэр буюу “Бэнс”-нээс хөгжиж, Хятад үндэстний “Дөрвөн их нэрт бүтээл” зэрэг бүлэгт роман, хувьсгалын тухай үлгэр жич: Монгол хүний өөрсдөө зохиосон буюу дахин үлгэрлэн бүтээсэн зэрэг үлгэрийн загварууд нь “Бэнсэн үлгэр”-ээс эш үндэстэй авсан байх магадлалтай гэж үзээд хуурын үлгэрийн аман хүүрнэлийг бид аман хүүрнэлийн сэдэв, агуулга хийгээд аман хүүрнэлийн урлаг гэх хоёр зүйлд зүйчлэн судлахыг зорьсон болно.

### Түлхүүр үг

Хуурын үлгэр, аман хүүрнэл, сэдэв агуулга, урлаг

### Удиртгал

Хуурын үлгэрийн аман хүүрнэлийг аман хүүрнэлийн сэдэв агуулга хийгээд аман хүүрнэлийн урлаг гэх хоёр талаас шинжлэв. Үүнд, хуурын үлгэрийн аман хүүрнэлийн сэдэв агуулгыг явцуу хийгээд дэлгэрэнгүй утгын талаас ойлгох нь хуурын үлгэрийн хөгжлийн явцад дахь хувьсал гэж үзэж байна. Хуурын үлгэрийн аман хүүрнэлийн загвар нь үйл явдлын загварчилсан шинж, туурвил зүйн тогтворжсон онцлогоор тодорч байна. Хуурын үлгэрийн аман хүүрнэл бол монгол аман хүүрнэлийн доторх өвөрмөц онцлог бүхий аман хүүрнэл юм. Хуурын үлгэрийн аман хүүрнэл нь дөрвөн утаст хуурын хөгжмийн аянд аялгуулан дуулж тоглодог урлаг болно. Тэр нь Өвөр Монголын зүүн хэсэгт өргөнөөр тархаж дэлгэрч “Бэнсэн үлгэр” хэмээх нэрийдэлтэй болжээ. Энэхүү нэрийдэл нь түүний хүүрнэлийн сэдэв агуулгатай шууд холбогдоно. Даруй хуурын үлгэр нь анхны шатандаа хятад үндэстний түүх, төрийн үлгэр, түүхэн сэдэвт туужсын дэвтэр буюу тэдгээрийн монгол орчуулгын дэвтрүүд нь хүүрнэлийн эх хэрэглэгдэхүүн болж байв.

Хуурын үлгэр нь хоёр зуу илүү жилийн хөгжлийн түүхэн явцад эх дэвтэр болох “Бэнс”-ээс хөгжиж, хятад үндэстний “Дөрвөн их нэрт бүтээл” зэрэг бүлэгт роман, хувьсгалын үлгэр жич: монгол хүний өөрсдөө зохион хэлсэн буюу нэмж баяжуулсан үлгэр зэргийг нэрлэх болсон ба “Бэнсэн үлгэр”-ээс өнөөдрийн хуурын үлгэр болж хөгжсөн байна. Хуурын үлгэрийн аман хүүрнэлийг бид аман хүүрнэлийн сэдэв агуулга хийгээд аман хүүрнэлийн урлаг гэх хоёр талаас шинжилж болно гэж үзэж байна.

### Судлагдсан байдал

Дундад иргэн улсын “Хуурын үлгэрийн судлал” бол орчин үеийн утга уран зохиолын судлалын салбарт нэлээд чухал судалгааны сэдэв юм. Хуурын үлгэрийн судлалыг товч өгүүлэхэд: Цогтын бичсэн “Хуурын үлгэрийн судлал” (2002), Хөх хот. Б. Ган “Хуурч ба хуурын үлгэрийн холбоо үлгэрт дуу”, (2006), Бүтээлт “Хуурч: Хорчины орон нутгийн уламжлал дундын хэлж дуулах урлагчин хийгээд түүний дуу хөгжим”, (2007), Луузарын “Зард хуурчдын судлал”, (2009), Цэцэнтуяа “Үлгэр дууны аман

\*Холбоо барих зохиогч: siqintuoya2008@163.com

хүүрнэлийн судлал”, (2009) он. Дүн Чингийн “Хуурчийн үлгэр-Зард”, (2010), Ренчиндоржийн “Туульч хуурчдын намтар бөө мөргөлийн яруу найраг”, (2012), Цогт, Эрхэмбаяр нарын “Хуурчдын аман түүх” (2009), Лин Чин Сүн, Хүй, Хун Ян нарын хамтран бичсэн “Монголжины хуурын үлгэр” (2012), Нямаа “Үлгэрийн тухай судлал”, (2013) зэрэг хуурын үлгэрийн тухай судалгааны ном зохиолыг дурдаж болно. Эдгээр хуурын үлгэрийн судлалын судалгааны чиглэл, дүгнэлт тодорхойллыг товчхон өгүүлэхэд: Хуурын үлгэрч болон үлгэр сонсогчийн холбоо харилцаа, хуурын үлгэр хэлэх тоглолтын нэг төрөл болох тухай, хуурын үлгэрийн амьд орчны судалгаа, хуурчдын намтар хуурын үлгэрийн утга агуулгын судалгаа голчлон судалсан боловч хуурын үлгэр болоод бэнсний үлгэрийн холбоо хамаарал, үүсэл гарлын асуудлын тухай судлагдаагүй болно.

Хуурын үлгэрийн аман хүүрнэлийн сэдэв, агуулга

Хуурын үлгэр нь эртнээс эдүгээг хүртэл нэг зүйлийн үлгэрийг хүүрнэж, сэдэв агуулга нь олон зүйлийн хувиралтын явцыг өнгөрөөжээ. Бид хуурын үлгэрийн аман хүүрнэлийн сэдэв агуулгыг түүний хөгжлийн явцад үндэслэн явцуу утга хийгээд дэлгэрэнгүй утга хэмээх хоёр талаас ойлговол зохилтой.

### *I. Явцуу утгын сэдэв агуулга*

Явцуу утгын хуурын үлгэр нь “Бэнсэн үлгэр”-ийг зааж буй. Даруй хятад үндэстний төр гүрний үлгэр, түүхийн үлгэр, түүхийн сэдэвт туужсын зохиолыг монгол хуурчид дөрвөн утаст хуурын аяар аялгуулж, үлгэрлэн хэлснийг хуурын үлгэр гэдэг байжээ. Тэдгээр нь үндсэндээ доорх мэт хэдэн зүйлийг багтаан зааж байдаг.

#### *1. Монголоор орчуулсан хятад үндэстний үлгэр*

Түүхийн сэдэвт туужсын бүтээл: “Гурван улсын үлгэр”, “Хан Улсын үлгэр”, “Тан Улсын үлгэр”, “Шүй хүүгийн үлгэр”

Чөтгөр сахиусны үлгэр: “Сахиус өргөмжилсөн үлгэр”

Зарга заалдаан, журам ёсны туужис: “Да Ба И”, “Сяо Ба И”, “Гурван хэлхээ таван үүрд”, “Бао гүнгийн хэрэг”

Монгол хүний өөрөө зохиосон “Бэнсэн үлгэр”: “Кү Ши Жуан”, “Чүнь Жиа Фү”, “Шан Яо Жуан”, “Шиэ Пи Жуан”, “Чиан Хү Жуан”

#### *2. Монголчуудын нийгэм амьдралыг тусгасан үлгэр*

Монгол үндэстний ардын аман зохиолоос хувирч ирсэн үлгэр: “Гаадаа мэйрэн”, “Тогтох”, “Данаабал”, “Балжиням заанаа”

Монгол хүний бичсэн туужсын зохиолоос хувирч ирсэн үлгэр: “Алмасын дуу”, “Аюуш баатар”, “Тал нутгийн хилэнгийн гал”, “Хөх судар”

Монгол үндэстний түүхийн хэрэг явдлаар сэдэвлэсэн үлгэр: “Өгэдэй мэргэн хааны үлгэр”, “Чингис хааны үлгэр”, “Мандухай сэцэн хатны үлгэр”, “Убаши хаан”, “Хубилай сэцэн хааны үлгэр”

#### *3. Хувьсгалын үлгэр*

“Тал нутгийн буун дуу”, “Буурал хүүхэн”, “Лиү Хү Лань”, “Мартагдашгүй байлдаан”

-Хуурын үлгэр гэдэг нэрийдэлд хуур хийгээд үлгэр гэх агуулга багтдаг. Үүнд хуур нь дөрвөн утаст хуурыг зааж, үлгэр нь хамаг анхандаа хятад үндэстний түүхийн үлгэр, төрийн үлгэр, түүхээр сэдэвлэсэн туужсын зохиолын монгол орчуулгын дэвтрийн үлгэрүүд байжээ. Тэдгээр орчуулгын дэвтрийг бэнс гэдэг байж. Хуурын үлгэрийг монгол бэнсэн үлгэр гэдэг байна. (Фрүник Фит, 1991, х.2) “Гурван улсын үлгэрийн монгол орчуулгын судлал” бол даруй үлгэрийн бэнсний судлал болно. Тиймээс хуурын үлгэрийг анхны утгаар нь “Бэнсэн үлгэр” гэдэг байсан нь учиртай байжээ.

Хуурын үлгэр нь хоёр зуу илүү жилийн хөгжлийн явцад сэдэв агуулгад ихээхэн хувиралт гарсан байдгийг бид дэлгэрэнгүй утгаас ойлгох болно. Хамгийн анх “Бэнсний үлгэр”-ийг хуурдан хэлдэг байснаа аажмаар хятад үндэстний бүлэгт роман, хувьсгалын үлгэр, монгол үндэстний бичгийн хүмүүсийн өөрөө зохиосон бүтээл хийгээд дахин зохиомжлох зүйлүүдийг хэлэх болсон байдаг. Жишээлбэл: Дээрх мэт сэдэв агуулгатай хуурын үлгэрийг бид өнөөдөр уламжлалт хуурын үлгэр гэх буюу хуучин үлгэр гэж хэлэх болсон нь хуурын үлгэрийн сэдэв агуулгад шинэ хуучны хувиралттай болсныг харуулж байна. Тэр нь одоо үед хуурч, урлагчид хуучин үлгэр буюу “Бэнсэн үлгэр”-ийг бүрэн бүтэн хэлж чаддаг хүмүүс цөөн болсон ба олонх залуу хуурч урлагчид богино үлгэр хэлэх болсноос үлгэр үйл явдалтай зүйл бүхнийг дөрвөн утаст хуурын аянд хэлэх болсон нь хуурын үлгэрийн сэдэв агуулгын шинэ нэгэн тэлэлт буюу хувиралтыг авчирчээ.

### *II. Сэдвийн дэлгэрэнгүй утга, агуулга*

Хуурын үлгэрийн сэдэв агуулгыг бид явцуу утгын талаас “Бэнсэн үлгэр”-ийн сэдэв агуулга хэмээн ойлгож болох бөгөөд дэлгэрэнгүй утгын талаас доорх мэт таван талын сэдэв агуулгыг багтааж болно.

1. Хятад үндэстний түүхийн үлгэр,

төр гүрний үлгэр, түүхийн сэдэвт туужсаар сэдэвлэсэн “Бэнсэн үлгэр”. Жишээлбэл: “Жүн Гүө Мү”, “Олон улсын үлгэр” мэтийн олон улсын системийн үлгэр; “Зүүн Хан улсын үлгэр”, “Баруун Хан улсын үлгэр” зэргийн Хан Улсын системийн үлгэр; “Сүй Тан Улсын үлгэр”, “Шүэй Ган Тан Улсаас урвасан нь” зэрэг Тан Улсын системийн үлгэр; “Өмнөд Умард Сүн Улсын үлгэр” зэрэг Сүн Улсын системийн үлгэр.

2. “Баруунш зорчсон тэмдэглэл”, “Шүй Хүгийн үлгэр”, “Гурван улсын үлгэр”, “Улаан асрын зүүдэн” зэрэг хятад үндэстний бүлэгт романы сэдэвт үлгэр.

3. “Дүн Цүнх Рүй”, “Лиү Хү Лань”, “Дэн Сяо Пингийн үлгэр”, “Мао Зэ Дунгийн үлгэр” зэрэг хувьсгалын сэдэвт үлгэр.

4. Монгол хүний өөрөө зохион хэлсэн үлгэр, үүнд дахин зохион боловсруулсан бүтээлийг ч багтаана. Жишээлбэл: Өсөхбуян хуурчийн өөрөө зохион хэлсэн үлгэр “Өнчин од”, “Баян тохойн тэмцэл” зэрэг.

5. Үлгэр үйл явдалтай зүйл бүхнийг хуурдан хэлж болдог болсон. Энэ зүйлийн үлгэр нь мөрийтэй уралдааны цагийн хязгаараас шалтгаалагдсан буюу эсвэл наадам тоглоомын шинж зэргээс болж шинээр ч зохиогдсон байдалтай. Жишээлбэл: “Анчин залуу” (Жүй Бао, 2017, х.35) гэх хуурын үлгэр.

Хуурын үлгэрийн аман хүүрнэлийн сэдэв агуулга нь түүний үүслийнхээ анхны шат үеэс тасралтгүй хувирч өөрчлөгдсөөр иржээ. Үүнд, явцуу утгын “Бэнсэн үлгэр”-ээс одоох утга дахь үлгэр үйл явдалтай зүйл бүхнийг дөрвөн утаст хуурын хавсарлага доор үлгэрлэж дуулах болсон нь маш их хувиралт болно. Тэр нь монгол хятад үндэстний соёлын харьцааг тусгасан төдийгүй монгол үндэстний түүх соёл, хуурч урлагчдын ур авьяасыг ч харуулсан хувиралтын явц болох юм.

#### *Хуурын үлгэрийн аман хүүрнэл*

Хуурын үлгэр нь урт хугацааны түүхийн явц, урлагийн хөгжилтийн аяндаа өөрийн гэх урлагийн шинж онцлогийг бүрдүүлжээ. Үүнд, үлгэр үйл явдлын загварчилсан шинж, дүрслэлийн туурвилын загварчилсан онцлог тодорч буй.

#### *Хуурын үлгэрийн аман хүүрнэлт загвар*

Загвар гэдэг бол хэвшиж тогтворжсон бүтэц болно. “Ямарваа ардын хүүрнэлийн төрөл зүйл нь харьцангуй тогтсон загвартай, энэхүү загвар нь олон зүйлийн ардын хүүрнэлд нийдэм оршиж

байна. Аман уламжлалын дунд ямар нэгэн хүүрнэлийн загвар оршиж, энэхүү загвараар төв болгож үлгэр нь түм мянган зүйлийн хувиралт үүснэ” (Цэцэнтуйа, 2009, х.83). Хуурын үлгэр нь эхлэлтээсээ төгсгөл хүртэл олон зүйлийн загваруудын нэгдлээр бүрэлддэг. Үүнд үйл явдлын хүүрнэлийн загвар маш тодорхой нэгэн онцлог болж тодорч байна. Хуурын үлгэр нь урт хугацааны уламжлагдан дамжигдах явцдаа бүрэн бүтэн үлгэр үйл явдлын хүүрнэлийн хэвшил загварыг бүрэлдүүлдэг. Тэр нь “төвлөрлийн загвар” (Хасбаатар, 2015, х.58)-т харьяалагдах болно. Тухайлбал, үлгэрийн бэлтгэл хэсэг, удиртгал хэсэг, эхлэлтийн хэсэг, гол хэсэг, төгсгөлийн хэсэг, тархалтын хэсэг хэмээн хураангуйлж болно. Хуурын үлгэр нь хүүрнэлийн уран зохиолын онцгой нэг стиль болсны хувьд бусад стилиэс ялгагдах өвөрмөц хүүрнэлийн хэлбэр хэвшил загварыг бүрэлдүүлжээ. Үүнд үйл явдлын хүүрнэлийн загвар, үлгэрийн илтгэмжийн загвар холбогдоно.

#### *Үлгэр, үйл явдлын хүүрнэлийн загвар*

Хуурын үлгэр нь адил бус хуурч, хэзээ ч, хаана ч хэлснээс үл хамааран гол үйл явдал нь үндсэндээ хувирахгүй байдаг. Түүний хүүрнэлийн хэлбэр бүтцийн үндсэн загварыг бүрэлдүүлэв. Хуурын үлгэрийн аман хүүрнэл дэх үйл явдлын зохиомжийн хэвшсэн загвар нь түүний нэг зүйл болно. Тэр нь үндсэндээ доорх мэт байдалтай.

*Оршил ая.* Холбооны ая, үлгэр завсарлахад татдаг ая, бас зарим бадгийн давталтын аятай адил. Энэ нь үлгэр эхлэх удиртгал загвар болж байна. Жишээлбэл:

Аралт сайхан хуур минь дээ  
Аяс нь таараад хүнгэнэнэ дээ  
Авьяас болоод билиг минь  
Аясыг нь дагаад хэлхвэл ээ  
Анхны тавьсан ерөөлөөрөө  
Аялгуут дуутай уулзсандаа  
Агширсан залуу сонсогчид олны

Амар мэндийг чинь асууж байна хи... (Шуан Чэн, Шуан Хэ, 30.20) хэмээн үлгэрээ эхлүүлдэг нь уламжлалт үлгэр хэлэх хэвшил, нэг зүйлийн үлгэрийн хүүрнэлийн загваршсан онцлогийг бүрэлдүүлсэн байна.

*Түүх тоочих ба баатрын хүүрнэл.* Энэ нь аль гүрний, хэн хүний үлгэр гэдгийг өгүүлж, үлгэрийн эхлэлт болдог байна. Хуурчаас хэлэх гэж байгаа үлгэрийнхээ түүхийг тоочиж, гол баатраа танилцуулан, үлгэрийн үйл явдалдаа суурь тавьдаг. Жишээлбэл: “Өгэдэй мэргэн

хааны үлгэр” гэх хуурын үлгэрт Чингис хааны үеэс Өгэдэй хааны үе хүртэл түүхийг дараалан товчлон өгүүлж “Өгэдэй хааны цаг болбол... «Хувилгаан оддын шастир» (Балжинням, 1982, х.69) хэмээх нэгэн иж үлгэр гарсан гэж үлгэрийн ирэлтийг танилцуулахаас эхэлжээ. Энд хуурч тухайн үлгэрээ хэлэх зорилт, үлгэрийн нэр ба аль төрийн аль хааны үлгэр гэдгээ бүрэн бүтэн товч тодорхой хэлдэг юм. Энэ бол хуурын үлгэрийн эхлэлтийн тогтворжсон загвар.

*Гол үйл явдал.* Гол үйл явдлын туурвил нь үүсэл, хөгжил, өрнөл, төгсгөлийн алхам дараа бүхий хүүрнэлийн загвар бүрэлджээ. Хуурын үлгэрт хамаг гол болж, бүхий л хуурын үлгэрт нэвтэрч байгаа үлгэр үйл явдлыг зааж буй. Жишээлбэл: “Өгэдэй мэргэн хааны үлгэр” бол дотоодын зальхайчдын дэгдээсэн урвалтыг төвшитгөснөөр гол үйл явдлаа болгосон хуурын үлгэр мөн. Шан Дунгийн Жинь Чүнь Шань оронд “Ин Сиүн Тиэнь Бао Тү” эрдэнэ илэрсэн явдлаар гол шижмээ болгож, Хуа Дин Юнь нар урвалтыг дэгдээснээр үйл явдал өрнөж, эцэст Юань Улсын баатрууд самууны хулгай нарыг баривчилснаар бүх үйл явдал дуусаж үлгэр төгсдөг. Ингэж тус хуурын үлгэр нь гол үйл явдлынхаа эхлэлт, сэдэл, өрнөл, оргил, төгсгөл гэх тогтворжсон дэс дараагаар эмх замбараатайгаар хүүрнэжээ.

Үлгэрийн илтгэх, дүрслэлийн загвар

Хуурын үлгэрийн хүүрнэлийн илтгэмж нь зохих хэвшсэн шинж бүхий загварыг бүрэлдүүлсэн байдаг. Адил бус хуурч тоглогчийн үлгэр хэлэх хэв намба нь адилгүйгээс болж үлгэрийн хэл хэллэгийн талд зөрөө гарах боловч нэг бүлэг хэвшиж тогтворжсон шинжтэй нийтийн хэллэг байдаг нь хуурын үлгэрийн аман уламжлалын нэгэн нууц жам хэмээн үзэж болно. Тэр нь хүүрнэлийн илтгэмжийг загваржсан шинжтэй болгожээ. Гэхдээ “тэр нь хэвшмэл биш харин амьдлаг тохируулалт мөн” (Сүеэ, 2017, х.41). Сүеэ гуай монгол хуурын үлгэрийн загварыг туршин өгүүлж гучин зүйлд ангилсан байдаг (Сүеэ, 2017, х.35).

*Үлгэр эхлэх, төгсгөх загваржсан илтгэмж.* Үлгэр эхлэхэд: “Салхин хаанаас үүснэ гэвэл сансар тэнгэрийн завхсаас шүү, шастирын салаа өлгөөд хэлэх нь... болох юм байна даа” гэх мэтийн илтгэмж хэлбэр бол хуурын үлгэрийн нэгэнт хэвшин тогтворжсон үлгэр эхлүүлэх тогтворжсон хэлбэр, загваржсан илтгэмж болсон байна. Энэ мэтчилэн “Үүл хаанаас үүснэ гэвэл, өндөр тэнгэрийн хаяанаас; үлгэр хаанаас үүснэ гэвэл, өмнө Тан Улсын... хааны хөддүгээр үеэс” зэрэг нэлээд тогтворжсон илтгэмж бүхий

хүүрнэлийн загвартай байдаг.

Хуурын үлгэрт хүүрнэгдэхүүний нутаг уснаас танилцуулан эхлэх мотив байдаг. Хуурын үлгэр “Өгэдэй мэргэн хааны үлгэр”-т Юань Улсын нутаг дэвсгэр жич: Чингис хаанаас Өгэдэй хаан хүртэлх үеийг танилцуулаад дараа нь сая үлгэрийн гол үйл явдалдаа ордог. Энэ мэт хуурын үлгэрийн эхлэлтийн мотив нь “Хорчины бусад аман хүүрнэлд нөлөөлсөн тухай үлгэрт дуунд хүүрнэгдэхүүний нутаг уснаас танилцуулан эхлэх нь нэг зүйлийн мотив болсон жишээ харуулж байна” (Цэцэн Туяа, 2009, х.67).

Хуурын үлгэрийн бүхий л үйл явдлын хүүрнэлээс үзвэл “Урьдаар сайн хүн зовж, муу хүн жарган, дараа нь сайн хүн жаргаж муу хүн зовдог” хүүрнэлийн загвар бол нийт монгол уран зохиолын уламжлалт хүүрнэлийн онцлогийг ч үзүүлж буй. Жишээлбэл: “Өгэдэй мэргэн хааны үлгэр”-т үлгэр эхэлмэгцээ Юань Улсын нэрт жанжин болох Дин Гүө Гүн, Сү Хүй Тинг Хуа Дин Юнь хилсээр хорлон алж, түүнийг “Улсаас урвагч” болгож гүтгэсэн байна. Үлгэрийн сүүлчийн хэсгээр Сү Хүй Тингийн хилсийг цагаатгаж, тэдний нэгэн гэр бүл ялгүй болсон, Ариун болон Шүй Тай Шуйг алсан Жан Күй шийтгэгдэж, Хуа овогтных бүр баривчлагдан алагдаж, Юаны цэргийн ялалтаар үлгэр төгсжээ. Иймэрхүү үлгэрийн үйл явдлын хүүрнэлийн загвар нь нийт хуурын үлгэрийн хүүрнэлийн загварын нийтлэг тал болсон байна. Хуурын үлгэр дэх баатруудын олонх нь бүр баярт төгсгөлтэй, дайснаа дарж, дархан цолоо мандуулан, баяр жаргалыг эдлэн төгсдөг нь монголчуудын эртнээс уламжилж ирсэн монгол уран зохиолын баярт төгсгөлийн мотивтой холбогдоно. “Өгэдэй мэргэн хааны үлгэр”-т Юань Улсын баатрууд нь байлдааны ашиггүй байранд байснаасаа эрэлхэг зориг, ид хүчиндээ хөвчлөгдөн, дайснаа дарж, дархан цолоо мандуулан, дайны ялалтад хүрдэг. Энэхүү эргэлтийн чанартай төгсгөл нь хуурын үлгэрийн баярт төгсгөлийн мотивтой нийцэж буй.

Дүрийн зан чанарыг туйлшруулсан илтгэмж. Баатрын дүрийг сайн муу, сайхан муухай, зөв буруу хоёр үзүүрт туйлшруулан дүрсэлдэг нь хуурын үлгэрийн хүүрнэлийн бас нэгэн загвар болжээ. Жишээлбэл: Зөв талын баатрыг

Бие дор хүрлийн гархины хуяг хуяглаж  
Тэргүүн дор битүү дуулга дарж  
Нүүрний өнгө цагаан, нүд гэрэлтэй  
Насны хэмжээ бас гучин насыг хүрээгүй  
Хөх морийг унажээ

Гарт болбол хагас алганы чинээ их дам илдийг хэрэглэнэ гэдэг бол эсрэг талын дайсны

## дүрийг

Нүүрний өнгө хөх

Биеийн өндөр есөн тохой шахуу

Хөх морийг унаж

Насны хэмжээ төдий хорин таван насыг өнгөрөөгүй

Гар дор төнгөн их шийдмийг барьжээ. (Цэцэн Туяа, 2009,х.67) хэмээн маш зөрөөтэй дүрсэлдэг байна. Дүрийг зөв тал, эсрэг тал гэж ялгалгүй адилхан загвараар дүрсэлсэн нь дүрслэлийн хувьд загварчилсан шинжтэй болов. Тэр нь дүрийн онцлог шинж, зан чанарыг дурайлгасан мөртөө хуурчийн овор зогсолтыг ч тодорхой илрүүлж чаджээ.

Жишээлбэл: Зөв талын баатрын дүрийг “Нүүрний өнгө хас мэт гэгээн, нүүрний өнгө гал ноцох мэт улаан, нүүрний өнгө гэрэлтэй” хэмээн тодруулаад, эсрэг талын баатрын дүрийг “Нүд гэдэг ас дээш босоод, гал улаан сахал гэдэг гадагш дотогшоо ургаад” хэмээн зэвүүн муухайгаар дүрсэлж дүрийн онцлог шинжийг тодруулсан нь мөн ч нэг зүйлийн загварын шинжтэй илтгэмж болжээ.

## Судалгааны арга зүй

Бид “Хуурын үлгэр” болоод “Бэнсний үлгэр”-ийн харилцаа холбоо хамаарлын судалгааг хуурчийн аман яриа, дуу бичлэг, зэрэгт дүн шинжилгээ хийж харьцуулах, бичиж авсан эх бичвэрт анализ дүгнэлт хийх, тус сэдэвт холбогдол бүхий судалгааны эх хэрэглэгдэхүүнүүдийг өөр хооронд харьцуулах, утга уран зохиолын талын үндсэн баримталдаг онолын арга зүй, он цаг дарааллын харилцаа холбооны асуудал, тус сэдвийг дагнан судлагч нарын судалгааны дүгнэлт тодорхойлол зэргийг өөрийн судалсан судалгааны үр дүнд тулгуур баримт болгон ажигласан болно.

## Судалгааны үр дүн

“Хуурын үлгэр”-ийн уламжлал болоод шүлэглэх хэв маяг, хүүрнэн өгүүлэх байдлыг ажиглан үзэхэд “Бэнсний үлгэр”-ийн уламжлалтай нэн төстэйгөөс гадна, хуурчдын уламжлалт үлгэр өгүүлэх, үлгэрийн сэдэв, утга агуулга, бүтцийн загвар, илтгэх арга, туурвил зүйн дотоод гадаад харьцаа гэх мэт туурвил зүйн үндсэн загварууд нэн төстэй бөгөөд агуулахууны хувьд “Бэнсний үлгэр”-ээс “Хуурын үлгэр”-ийн үлгэрлэх загварчлал нь үлгэрлэн үүссэн болохыг бид дээр судлан авсан эш үндэс, баримтаас ажиглагдаж байгааг нотлохыг зорьсон болно.

## Дүгнэлт

Үлгэрлэн хүүрнэх ба шүлэглэн аялгуулан шүлэглэх нь хуурын үлгэрийн уламжлалын хэвшилт загварыг бүрэлдүүлсэн бөгөөд иймэрхүү хэлбэр нь монголын уран зохиолын үргэлжилсэн үгийн урлагийн шүлэглэсэн хэлбэрийн эх үндэс болж байна. Тиймээс тус хуурын үлгэрийг уламжлах хэв маяг нь “Дэлхийн уран зохиолын түүхэнд түгээмэл оршиж хамтын үзэгдэлд” (Цогт, 2002, х.173) шинжийн нэгээхэн хэсэг бол хуурын үлгэрийн хүүрнэлийн загвар болоод шүлэглэлт үлгэр үлгэрлэх уламжлалт арга юм. Энэхүү аман урлагийн хэлбэрийг хуурын үлгэр сонсдог хүн бүхэн алдалгүй мэддэгээс энд жишээлэхийг товчилбол: Хуурын үлгэрийг үлгэрлэх аргыг чөлөөтэй болгосон төдийгүй, утгыг лавшруулан гүнзгийрүүлсэн талтай. Хүүрнэн тоочсон зүйлийг дахин уянгалж үзүүлэх, эсвэл уянгалж дуулсан зүйлд тоочилт тайлбар хийхээр дамжуулан сонсогчдод гүн гүнзгий сэтгэгдэл төрүүлж чаддаг. Өөрөөр хэлбэл, хуурчдын хувьд хуурын үлгэр нь жүжиглэлт бөгөөд нэгэн төрлийн үлгэрлэн хэлж тоглохын арга хэлбэр болж байна. Үлгэр хэлэх явцад тархины ой санамжид буй үлгэрийн үйл явдал агуулга хэлбэрийн зүйлсийг мартаж зарим нэг зүйлсийг орхигдуулах логик алдагдуулахгүй байх бас нэг шалтгаан нь аялгуулан шүлэглэх явцад бол хуурын аялгуу айзам хэмнэлийн түр амсхийх зуур үлгэрийн дараагийн үйл явдлыг санагалзах бас нэгэн түр хүлээлгийн арга ч болж байна.

## Ном зүй

- Фрүник Фит. (1991). Хуурч таваарчин хийгээд монгол бэнсэн үлгэрийн судлал”. *Монгол судлал эрдэм шинжилгээний сэтгүүл*. Хоёр дугаар хугацаа. 2. Хөх хот.
- Жүй Бао. (2017). *Гурван улсын үлгэрийн монгол орчуулгын судлал*. Өвөр Монголын Их Сургуулийн хэвлэлийн хороо. Хөх хот.
- Бай Жин Чүнь. (2017). *Анчин залуу хуурын үлгэр*. Хөх хот.
- Хасбаатар. (2015). Хуурын үлгэрийн Өнчин од дахь хөгжөөнт нохойн хүүрнэлийн үйлдэл. *Өвөр Монголын Их Сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл*. Зургаа дугаар хугацаа.58. Хөх хот.
- Балжиням хуурч. (1982). *Хувилгаан оддын шастир*. Зуун Удын Радио хорооны шингээлт. Хөх хот.
- Сүеэ. (2017). *Хуурын үлгэрийн үүсэл хөгжил бүтэц жич: Соёл урлаг судлал*. Өвөр

- Монголын Их Сургуулийн хэвлэлийн хороо. Хөх хот.  
 Сүеэ. (2017). Хуурын үлгэрийн гол мотив, загвар, замбараагийн судлал. *Өвөр Монголын Их Сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл*. Нэгдүгээр хугацаа. Хөх хот.  
 Цэцэн Туяа. (2009). *Үлгэрт дууны аман үлгэрийн судлал*. Өвөр Монголын Соёлын хэвлэлийн хороо. Хөх хот.  
 Шуан Чэн. (2015). *Шуан Хэ хуурчийн хэлсэн “Хубилай сэцэн хааны үлгэр”-ийн 30 бүлэг*. Хөх хот.

### Oral narrative of Khuur story

Tsetsentuya.B\*  
 School of Mongolian study,  
 Inner Mongolia University

---

#### Abstract

Expressing about vocal narrative of tale on “morin huur” musical instrument sound is the future of vocal narrative of tale on “morin huur” musical instrument sound and Mongolian vocal narrative. Vocal narrative of tale on “morin huur” musical instrument sound is the general art of storytelling and singing on soundtrack of “morin huur” musical instrument which has 4 strings. The tale is widely spread through southern Inner Mongolia and has general term “Bensen tale”. The term directly related with tale’s topic and content. Immediately, the tale on “morin huur” musical instrument sound turned to the source of narratives via Chinese traditional history, political story, historic theme novel books or their Mongolian translations books. Again, the tale on “morin huur” musical instrument sound throughout the development process of two hundred years was developed from “Bens” book of tale on “morin huur” musical instrument sound, later turned to call chapter roman of Chinese traditional “4 great creations”, revolution tale ps: the tale that Mongolian person created and revised for himself etc, and today’s tale on “morin huur” musical instrument sound was sourced from “bensen” tale. We could analyze the tale on “morin huur” musical instrument sound from the 2 sides: topic and content and from art of vocal narrative.

#### Keywords

Khuur story, oral narrative, topic, content, art

---

\* Corresponding author: siqintuoya2008@163.com